

Хөгжлийн бэрхшээл ба жендерт  
суурилсан хүчирхийлэл

# Тунгаан бодох асуулт

Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд хөгжлийн бэрхшээлгүй охид, эмэгтэйчүүдтэй харьцуулахад жендерт суурилсан хүчирхийлэлд өртөхөд юу нөлөөлдөг вэ? Тэд илүү өртөмтгий юу эсвэл илүү хамгаалагдсан байдаг уу?

Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр ялгаатай юу?

Хөгжлийн бэрхшээлтэй охид эмэгтэйчүүдэд хүчирхийлэл үйлдсэн хүмүүст юу тохиолддог вэ? Тэднийг нийгэм, олон нийт мэддэг үү? Ямар шийтгэл оногдуулдаг вэ?

Бэлгийн хүчирхийлэл, дарамтанд өртсөн хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдэд гэр бүлийн гишүүд нь хэрхэн ханддаг вэ? Түүнийг хэрхэн дэмжиж тусалдаг вэ?

Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөхгүйн тулд ямар арга зам хэрэглэдэг вэ? Тэднийг хамгаалдаг зүйл нь юу вэ? Гэр бүл, найз нөхөд, ажлын хамт олны зүгээс юу хийх хэрэгтэй вэ?

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хөгжлийн бэрхшээлгүй хүмүүстэй харьцуулахад жендерт суурилсан хүчирхийлэлд адилхан өртдөг ба зарим талаар тэднийг илүү өртөмтгий буюу өртөх эрсдэлтэй гэж үздэг.
- Жендерт суурилсан хүчирхийлэлд өртөх эрсдэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дунд хөгжлийн бэрхшээлийн төрлөөр ялгаатай. Оюуны бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл ихтэй байдаг бол харааны бэрхшээлтэй иргэд эдийн засгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл илүү байх жишээтэй.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүчирхийлэлд өртсөн талаараа төдийлөн ил тод нээлттэй хэлдэггүй. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хаана хэнд хандахаа мэдэхгүй, эсвэл боломжгүй байдагтай холбоотой байж болно. Нөгөө талаар хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст итгэхгүй аль эсвэл энэ талаар мэдээлснээс нүүгээд өнгөрсөн нь дээр гэж үзэх хандлагатай холбоотой.
- Хүчирхийлэл үйлдэгчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сул дорой гэж үзэн “олзлох” хандлагатай байдаг. Хүчирхийлэл үйлдэгчид хэнд ч мэдэгдэхгүйгээр хүчирхийллээ үйлдсээр байх магадлалтай.
- Хүчирхийллийн хохирогч болсон хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний гэр бүлийнхэн дуугай өнгөрөөх, нуун дарагдуулах хандлагатай байдаг нь хүчирхийлэл үйлдэгчийг улам өөгшүүлдэг.

- Эм, эмчилгээний бодис ба нэмэлт тоног хэрэгслийг хурааж авах, өгөхгүй байх
- Хооллох, хувцаслах, усанд орох, ариун цэврийн өрөө ашиглах гэх мэт хэрэгцээг зориуд тасалдуулах, хясах боох
- Сонсголын төхөөрөмжийг зориудаар нуух, эвдэх сүйтгэх
- Халамжийн мөнгийг нь хурааж авах, булаах дээрэмдэх, өмнөөс нь захиран зарцуулах
- Харилцаа холбооны хэрэгслийг ашиглахыг хянах боогдуулах
- “Онгон” байдлыг нь далимдуулж хүчиндэх, хүчээр бэлгийн хавьталд орох
- Эрт гэрлүүлэх
- Албадан гэрлүүлэх
- Хүчээр үр хөндүүлэх, үрийн суваг боох, жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгсэл хэрэглэх
- Хүчээр тусгаарлах, хорионд байлгах гэх мэт

# Эрсдэл ба эмзэг байдал

- Эмэгтэй хүн байх, дээр нь хөгжлийн бэрхшээлтэй байх нь нийгэмд эзлэх байр суурь бага байхад хүргэдэг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхах хандлагатай холбоотой.
  - Тусгаарлалтанд байлгах
  - Аливаа зүйлийн гадна үлдээх
- Нийгмийн боломжийг тэгш хүртэж чаддаггүй.
  - Боловсрол
  - Ажил эрхлэлт
  - Амьжиргааг тэтгэх санхүүгийн дэмжлэг
- Нийгэм дэх сөрөг ойлголт, тогтсон хандлага
  - Гэр бүлийн гишүүдийн хандлага
  - Орон нутгийн иргэдийн хандлага
  - Эмч мэргэжилтнүүдийн хандлага
  - Үйлчилгээ үзүүлэгчдийн хандлага
- Олон нийтийн уулзалт, арга хэмжээнд оролцох боломж хязгаарлагдмал.

- Шийдвэр гаргахад тэдний санаа бодлыг асуудаггүй, дуу хоолойг сонсдоггүй. Тэдний саналыг авч хэлэлцдэггүй.
- Тэднийг асрамж халамжийн төв рүү илгээх эрсдэл байдаг.
- Хүчирхийлэл үйлдэгч нь тэдний хамгийн ойрын хүн магадгүй асран халамжлагчид нь байх нь бий.
- Хүчирхийлэл дарамтын талаар хэлж ярьсан ч хүмүүс авч хэлэлцдэггүй, тоодоггүй, заримдаа хүний анхаарал татах гэж байна гэж ойлгодог.
- Айж ичдэг.
- Итгэж найддаг.
- Мэдээллийн нууцлал байхгүй.
- Газар зүйн байрлал
- Нийтийн тээврийн хүртээмжгүй байдал
- Санхүүгийн боломжгүй байх

- Дасгал ажил